

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2014 оны 07 дугаар сарын 02-нд болов. Тус хурлаар Монголбанкны хүний нөөцийн удирдлагын талаар Тамгын газрын захирлын мэдээлэл, Монголбанкны 2013 оны санхүүгийн тайланд аудит хийсэн “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн аудиторуудтай санал солилцсон тухай Зөвлөлийн гишүүний мэдээлэл, Монголбанкны 2013 оны санхүүгийн тайланд аудитын компаниас өгсөн дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж тус тайланд Хяналтын зөвлөлөөс өгөх санал, зөвлөмжийн тухай гишүүн Д.Нямаагийн мэдээлэл, Монголбанкны 2013 оны ашиг хуваарилсан нөөцийн сангуудын байдалтай танилцсан тухай Зөвлөлийн гишүүний мэдээллийг тус тус хэлэлцэв.

Хэлэлцсэн асуудлаар зохих шийдвэр гарган Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөмж хүргүүлж УИХ-ын байнгын хороонд явуулахаар тогтов.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ